



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/91

Алтанбулаг

Хугацаат цэргийн албаны ээлжит
татлага зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам"-ын 2.2.2 дахь заалт, 2020 оны мн/203 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны н/51 дүгээр тушаал, Батлан хамгаалахын сайд, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 4.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны А/113 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтанбулаг сумын 2021 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.

2.2021 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн татлагад 1996 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2003 оны 05 дугаар сарын 10-ны хооронд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

3.Цэрэг татлагын анкетыг 18-25-н насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн тус бүрд бүртгэн шивж, "Байгууллагын баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт"-ын дагуу хадагалмжийн нэгж үүсгэн хадгалахыг багийн Засаг дарга /Б.Баттулга, Г.Жамбалдорж/ нарт даалгасугай.


4.Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа иргэдэд Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн үндсэн /Цусны ерөнхий, шээсний ерөнхий, биохимийн /сахар, АСАТ, АЛАТ, креатинин, мочевин/ элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгийн шинжилгээ/ төрлийн шинжилгээг бүрэн хийлгэж, анкетад нь хавсарган өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг явуулах, цэргийн албанд тэнцсэн иргэдийг PCR-ын шинжилгээнд бүрэн хамруулж цэргийн штабт хүлээлгэн өгч ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбямба/-д даалгасугай.

5.Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, татагдагчдад Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/536, А/537 дугаар тушаалын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан коронавирус (COVID-19)-ээс урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрвэл мөн сайдын 2020 оны А/135 дугаар тушаалын дагуу ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбямба/, сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ү.Янжиндулам/ нарт үүрэг болгосугай.

6.Цэрэг татлагын 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байх арга хэмжээ авахыг сумын Засаг даргын орлогч /Х.Отгонжаргал/-д даалгасугай.

7. 18-27 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрд зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа тотоосон цагт бэлэн байлгах, тэдгээрийн цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, гэрийн шаахай /тавчиг/, 4-5 ээлжийн амны хаалт /маск/-тай, нийгмийн даатгалын дэвтэр, 2 хувь эрүүл мэндийн үзлэгийн анкет, 4 хувь цээж зураг бүрдүүлж ирүүлэхийг багийн Засаг дарга /Б.Баттулга, Г.Жамбалдорж/ нарт даалгасугай.

8. Цэрэг татлага зохион байгуулж, хугацаат цэргийн албанд тэнцсэн залуусыг сумаас үдэн гаргах үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа /Д.Наран/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОТГОНЦОГТ

